



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/203.

Мандалговь


Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл  
олгох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 20 дугаар зүйлийн 20.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 30 дугаар зүйлийн 30.1.6, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Насан туршийн боловсролын сургалтын төвд дүйцсэн хөтөлбөрийн сургалт, гэр бүлийн боловсрол, иргэний боловсрол, гоо зүй мэдрэмжийн боловсрол, ёс суртахуун төлөвшлийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, санхүүгийн боловсрол, бичиг үсгийн сургалтуудыг нийгмийн бүх орчинд албан бус сургалтын хэлбэрээр тасралтгүй олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 06 сарын 07-ны өдрөөс 4 жилийн хугацаагаар олгохыг Боловсрол, соёл урлагийн газар (Ц.Уранбямба)-т зөвшөөрсүгэй.

2. Насан туршийн боловсролын төвийн сургалтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Боловсрол, соёл, урлагийн газар (Ц.Уранбямба)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210590